



УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ.
“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР НЭГ” ОНӨААТУГ-ЫН
ЗАХИРАЛ *С.БАТЦЭНГЭЛ* С.БАТЦЭНГЭЛ
2024 оны 09 сарын 08-ний өдөр

0024070446
ХТУ7653 ® 7946089

Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага

Нийлүүлэх бараа бүтээгдэхүүн нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Ерөнхий шаардлага:

Үг барааг нийлүүлэх компани нь дараах шаардлагуудыг хангасан байна.

- Тендерт оролцогч нь тендерийн материал хүлээн авах хугацаанд техникийн тодорхойлолтод дурьдсан бараа бүрээс нэг ширхэгийг ТШХ-д тухайн хаягаар авчирч өгнө. /Буцааж олгоно/.
- Тендерт оролцогч нь өөрийн нэр бүхий шошгыг унахааргүй сёж бэхэлсэн байна.
- Тендерийн баримт бичигт заасан тоны хувцасны чанар нь засиалагчид анх ирүүлсэн 1 ш загварын хувцаснаас материал, чанар /гараар мэдрэхэд ялгаагүй/, өнгө, хийцийн хувьд ялгаагүй, өнгө зөрүүгүй, адил байна. Ялгаа гарсан тохиолдолд Захиалагч ирүүлсэн хувцасыг бүгдийг Гүйцэтгэгчид бөөнөөр буцааж, тендерийн бичиг баримтад заасан, шаардлага хангасан хувцасаар солиулна.
- Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
- Бүх хувцас хэрэглэлийг хийсэн эсхүл түүнд орсон материал бүр нь хүний биед сөрөг нөлөөгүй, аливаа цочрол, шархлаа үүсгэхээргүй, биеийн хөлстэй урвалд орохгүй зориулалтын хувцасны материалыаар хийгдсэн байна.
- Төмөр болон металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүйгээр байна.
- Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин механик, элементүүдэд ороолцолдоо оргүй байна.
- Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар, энгийн болон химиин аргаар цэвэрлэх боломжтой ус, тос, масло нэвтрүүлэхгүйгээр байна.
- Угаалга цэвэрлэгээний дараа агшиж сунахгүй буюу өмсгөлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байх сайн чанарын материалыаар хийгдсэн байна.
- Тендерт шалгарсан тохиолдолд гэрээ байгуулагдсан даруй 42,44,46,48,50,52,54,56 хэмжээнүүдээс 1 ком загвар ирүүлж өмсгөлийг тааруулж үзэх боломжтой байна. Энэхүү хэмжээгээр хувцасны хэмжээг тодорхойлсны үндсэн дээр захиалгыг гүйцэтгэнэ.

Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно.

ХАВСРАЛТ №1

ӨВЛИЙН АЖЛЫН ХОС ХУВЦАС /КУРТКА, ӨМД/

Ажлын хувцас нь "Ажлын тусгай хувцас"-ны өрөнхий шаардлага MNS 13688:2000 Монгол улсын стандартыг хангасан байна.

№	Үзүүлэлт	Өгөгдөл
1	Өнгө	Хар хөх, улаан оруулгатай
2	Материал	Холимог даавуу
3	Чанар	<p>Ажлын хувцасны чанар нь хэрэглээний болон технологийн тодорхойлолтод хэрхэн нийцсэн, хүний биед таарч байгаа байдлаар тодорхойлно.</p> <p>Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чанартай байна.</p> <p>Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна.</p> <p>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согогтүй, заасан өнгөнөөс зэрөөгүй байна.</p>
4	Хэмжээ	<p>Захиалгачийн заасан хэмжээтэй байна.</p> <p>Өвлийн улиралд өмсөх хувцас нь -25C -40C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна.</p> <p>Куртка нь хар хөх өнгөтэй, мөр, нурууны хэсгээр улаан оруулгатай байна.</p> <p>Куртканы хэмжээг цээжний тойрог болон чацын хэмжээгээр хэмжин авч тодорхойлно.</p> <p>Хувцас бүрт цацуулагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь 50 мм-ийн өргөнтэй байна. Энгэр болон ар нуруунд гэрэл ойлгогч туузыг хөндлөн оёно.</p> <p>Куртка хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна.</p> <p>Куртканы зах цахилгаандсан тохиолдолд хүзүү барихааргүй чөлөөтэй байна.</p>
5	Үзүүлэлт	<p>Куртканы ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй нь 50 мм-аас багагүй далд манжаткатай үргэлж байна.</p> <p>Куртканы урд талд хормой хэсэгтээ хөндийрүүлэгчтэй 22x19 см хэмжээтэй, тагтай ил халаастай, энгэртээ өргөн нь 10 см-ээс багагүй гар хийх чөлөөтэй ташуу халаастай байна. Энгэрийн халаасын өвлийн тохируулан дотор талд нь цахилгаантай хийнэ.</p> <p>Куртканы дотор талд жавар хаасан дулаалгатай байна.</p> <p>Куртка өмдний хөндийрүүлэгчтэй халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно.</p> <p>Өмдний бүс хэсэг нь нуруу болон бүсэлхийн хэсгээр дулаан байхад зориулсан мөрөвчтэй байна. Урд тал нь цахилгаантай байна.</p> <p>Өмдний гуяны гадна талд наалддаг бүхий тагтай, хөндийрүүлэгчтэй ил халаастай байна. Хэмжээ: 18x18 см хөндийрүүлэгчийн өргөн 0,2 см байна.</p> <p>Өвдөг, тохой, өвдөгний хэсгээр нэмэлт давхарлагаатай хийгдсэн байна.</p> <p>Өмд шуумгандаа битүү хагалбартай, цахилгаантай байна. Шумагны өргөн хэт өргөн биш 20-23 см байна.</p> <p>Өмдний шуумаг хэсэгт гэрэл ойлгогчтой 50 мм-ийн туузаар тойруулан давхарлаж оёсон байна.</p> <p>Өнгө үзэмжтэй, өмсөхөд звтэй байна.</p>
6	Лого	Компаний таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. Лого нь дугуй хэлбэртэй 6,5 см диаметр хэмжээтэй байна. Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 5 см өндөртэй том үсгээр шар өнгөөр оёсон байна.
7	Загвар	Өвлийн өмд, хүрэм эрэгтэй, эмэгтэй загвартай байна.

ХАВСРАЛТ №2**ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ ЦАМЦ**

Ажлын хувцас нь “Ажлын тусгай хувцас”-ны ерөнхий шаардлага MNS 13688:2000
Монгол улсын стандартыг хангасан байна.

№	Үзүүлэлт	Өгөгдөл
1	Өнгө	Цагаан саарал өнгөтэй, мөр, нурууны хэсгээр улаан оруулгатай.
2	Материал	Холимог даавуу байна.
3	Чанар	<p>Ажлын хувцасны чанар нь хэрэглээний болон технологийн тодорхойлолтод хэрхэн нийцсэн, хүний биед таарч байгаа байдлаар тодорхойлно.</p> <p>Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чанартай байна.</p> <p>Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна.</p> <p>Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.</p>
4	Хэмжээ	Захиалагчийн заасан хэмжээтэй байна.
5	Үзүүлэлт	<p>Цамцны хэмжээг цээжний тойрог болон чацын хэмжээгээр хэмжин авч тодорхойлно.</p> <p>Хувцас бүрт цацууллагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь 50 мм-ийн өргөнтэй байна. Энгэрт болон ар нуруун хэсэгт гэрэл ойлгогч туузыг хөндлөн оёно.</p> <p>Цамц нь хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна.</p> <p>Цамцны зах нугалдаг, цахилгаандсан тохиолдолд хүзүү барихааргүй чөлөөтэй байна.</p> <p>Цамцны ханцуй хэт өргөн биш стандартын дагуу байна. Ханцуй нь 50 мм-ээс багагүй, далд манжаткатай үргэлж байна.</p> <p>Цамцны цахилгаан бат бөх, далдлагчтай байна.</p> <p>Цамц нь хөндийрүүлэгтэй, халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно.</p>
6	Лого	Компаний таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. Лого нь дугуй хэлбэртэй 6,5 см диаметр хэмжээтэй байна. Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 5 см өндөртэй, том үсгээр шар өнгөөр оёсон байна.
7	Загвар	Цамц эрэгтэй, эмэгтэй загвартай байна.

ХАВСРАЛТ №3**ЖОЛООЧИЙН ХАНТААЗ**

Ажлын хувцас нь “Ажлын тусгай хувцас”-ны өрөнхий шаардлага MNS 13688:2000
Монгол улсын стандартыг хангасан байна.

№	Үзүүлэлт	Өгөгдөл
1	Өнгө	Цайвар цэнхэр өнгөтэй, мөр, нурууны хэсгээр цайвар ногоон оруулгатай байна.
2	Материал	Холимог даавуу байна.
3	Чанар	Хантаазны чанар нь хэрэглээний болон технологийн тодорхойлолтод хэрхэн нийцсэн, хүний биед таарч байгаа байдлаар тодорхойлно. Материал нь угаахад агшдаггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чанартай байна. Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна Бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
4	Хэмжээ	Захиалагчийн заасан хэмжээтэй байна.
5	Үзүүлэлт	Хантаазны хэмжээг цээжний тойрог болон чацын хэмжээгээр хэмжин авч тодорхойлно. Хантааз бүрт цацуулагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь 25 мм-ийн өргөнтэй байна. Энгэрт болон ар нуруун хэсэгт гэрэл ойлгогч туузыг хөндлөн оёно. Хантааз нь хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна. Хантаазны урд болон хормой хэсэгтээ 200x180 мм хэмжээтэй, тагтай ил халаастай, энгэртээ өргөн нь 100 мм-ээс багагүй гар хийх чөлөөтэй халаастай байна.
6	Лого	Компаний таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. Лого нь дугуй хэлбэртэй 65 мм диаметр хэмжээтэй байна. Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 25 мм өндөртэй, том үсгээр шар өнгөөр оёсон байна.
7	Загвар	Цамц эрэгтэй, эмэгтэй загвартай байна.

БОЛОВСРУУЛСАН:

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ХӨДӨЛГӨӨНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАЛ, ЭРҮҮЛ АХУЙ
ХАРИУЦСАН АЛБАНЫ ДАРГА..... /Х.ЦОГХҮҮ /

ХАБЭА-н 2024 оны сүүлийн хагас жилийн захиалга

2024.09.06

Д/д	Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, бусад зүйлс	1 дүгээр бааз	Үнэ	Тайлбар
Ажилчдын ажлын хувцасны тоо (Зүн)				
	Албан тушаал	Хувцас	Гутал	
1	Техникийн хэлтсийн засварчид (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	30ш	30 хос	
2	Засварын инженер (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	3ш	3 хос	
3	Шалгах механик (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	6ш	6 хос	
4	Тоног төхөөрөмжийн засварчин (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	7ш	7 хос	
5	Угаалгын оператор (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	3ш	3 хос	
6	Тэрэг тавигч (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	12ш	12 хос	
7	Тэрэг угаагч (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	25ш	25 хос	
8	Түгээгч (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	5ш	5 хос	
9	Мөнгө тоологч (бомбер захтай цамц)	13ш	-	
10	ХАБЭААХАжилтан (ажлын өмд, цамц, богино түрийтэй нимгэн гутал)	4ш	4 хос	
11	Удирдлага, инженер техникийн ажилчдын зуны хувцас (бомбер захтай цамц)	60ш	-	
12	Эмч, сувилагч (халаад)	2ш	-	
13	Үйлчлэгч (үйлчлэгчийн хувцас)	7ш	-	
14	Жолоочийн зуны хантааз	380ш	-	
Ажилчдын ажлын хувцасны тоо (Өвөл)				
	Албан тушаал	Хувцас	Гутал	
15	Техникийн хэлтсийн засварчид (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	30ш	30 хос	
16	Засварын инженер (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	3ш	3 хос	
17	Угаалгын оператор (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	3ш	6 хос	
18	Шалгах механик (ажлын зузаан өмд, куртик)	6ш	7 хос	
19	Тоног төхөөрөмжийн засварчин (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	7ш	3 хос	
20	Тэрэг тавигч (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	12ш	12 хос	
21	Тэрэг угаагч (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	25ш	25 хос	
22	Түгээгч (ажлын зузаан өмд, куртик, урт түрийтэй зузаан гутал)	5ш	5 хос	
23	Мөнгө тоологч (бомбер захтай цамц)	13ш	-	
24	ХАБЭААХАжилтан (ажлын зузаан өмд, куртик, богино түрийтэй зузаан гутал)	4ш	4 хос	
25	Удирдлага, инженер техникийн ажилчдын зуны хувцас (бомбер захтай цамц)	60ш	-	
26	Эмч, сувилагч (ажлын зузаан өмд, куртик, богино түрийтэй зузаан гутал)	2ш	2 хос	
27	Үйлчлэгч (ажлын зузаан өмд, куртик, богино түрийтэй зузаан гутал)	7ш	7 хос	
28	Жолоочийн өвлийн хувцас (бомбер захтай цамц)	380ш	-	